



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/71

Жаргалант

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.3, 19.2.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Баян-Өлзийт багийн “Энгэр булаг” гэх газар (N48.2724 E112.1659) хаваржиж буй малчин С.Наранбаатарын суурьт мал амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн тул 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан Баян-Өлзийт багийн Энгэр булаг гэх газарт ариутгалын постыг томилж ажиллуулахыг Тамгын газрын дарга Х.Баасансүрэнд үүрэг болгосугай.

3.Сэжигтэй бүсэд байгаа малчин Т.Алтаншагай, Б.Мөнхбат, 3.Болдбаатар, Г.Ганбаасан нарын малд эмнэл зүйн үзлэг хийж, халдварын эх үүсвэртэй, өвчтэй, халдварын сэжигтэй мал амьтныг тусгаарлаж, шүлхий өвчинтэй тэмцэх мал эмнэлгийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг “Эм Тун” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Э.Батцэцэг)-т даалгасугай.

4.Сэжигтэй бүсийн айл өрхийн хүн, малыг гадагш шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байхыг хэсгийн төлөөлөгч (О.Эрдэнэдалай)-д даалгасугай.

5.Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу Мал эмнэлгийн нэгжийн эмч, түүний мэргэжилтнийг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, өвчтэй малын арчилгаа, маллагаа, тэжээлийн нөхцөлд хяналт тавих, шаардагдах халдваргүйтгэлийн бодис, хөдөлмөр хамгааллын хувцасаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (О.Банхар)-т, ажлын гүйцэтгэлийн тайланг 7 хоног бүр Засаг даргын зөвлөл болон холбогдох дээд газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн Тархвар зүйч (Э.Батдаваа)-д, Мал амьтны сэг зэмийг булж устгахад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны улсын хяналтын байцаагч (Б.Баярмагнай) нарт тус тус даалгасугай.

6.Тандалт, халдваргүйжүүлэлт, сэг зэм устгалын ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, голомтын бүс, сэжигтэй бүс хамгаалалтын бүсийн цэг зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




О.ДАВААЖАРГАЛ

232501167

C. 400

Q. J. Lee



Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын
16-ний өдрийн А/71 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тандалт хийх ажлын хэсэг

Ахлагч:Тархвар зүйч Э.Батдаваа

Гишүүн:Баян-Өлзийт багийн Засаг дарга Х.Амарбаясгалан

Гишүүн:Жолооч Т.Уугантүшиг

Халдваргүйтгэл хийх ажлын хэсэг

Ахлагч:"Эм Тун" малын эмч Э.Батцэцэг

Гишүүн: Онон багийн Засаг дарга Э.Бат-Орших

Сэг,зэм устгалын ажлын хэсэг

Ахлагч:Байгаль орчны Улсын байцаагч Б.Баярмагнай

Гишүүн:Байгаль хамгаалагч Д.Батбаяр

Гишүүн:Жолооч Ц.Цэнгэл



Норолин сумын шүлхий өвчний сэжигтэй тохиолдлын зураглал



Голомтын өрх

С.Наранбаатар


СЭЖИГТЭЙ БҮСИЙН ӨРХҮҮД

С.Ганбаасан

Б.Мөнхбат

Т.Алтаншагай

Ц.Болдбаатар



Таних тэмдэг

-  голомтын_бүс_1
-  Сэжигтэй бүс 05
-  Хамгаалалтын бүс 02

1:750,000

Зураглал гаргасан:

Тархвар зүйч

Э.Батдаваа